



МОНГОЛ УЛС
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2016 оны 12 сарын 23 өдөр

Дугаар 249

Улаанбаатар хот

Төрийн албаны зөвлөлийн
Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх Салбар
зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн "Гурав"-ын 3.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 1.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 105 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүний нийтлэг жишиг", Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн албаны зөвлөлийн Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх Салбар зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн баталсугай. Үүнд:

Салбар зөвлөлийн дарга: - Төрийн нарийн бичгийн дарга,
Гишүүд: - Төрийн захиргааны удирдлагын газрын дарга,,
- Бодлого, төлөвлөлтийн газрын дарга,,
- Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга,
- Хяналт-шинжилгээ, дотоод аудитын газрын дарга,
- Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга.

Салбар зөвлөлийн
нарийн бичгийн дарга: - Хүний нөөцийн бодлого, зохицуулалт хариуцсан мэргэжилтэн.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах, дарга, нарийн бичгийн дарга нарыг томилох тухай" Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 131 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын "Нэг"-ийн 5 дахь хэсэг, мөн тогтоолын 2 дугаар хавсралтын "Нэг"-ийн 2 дахь хэсэг, "Төрийн албаны зөвлөлийн Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай" мөн Зөвлөлийн 2015 оны 62 дугаар тогтоол, "Төрийн албаны зөвлөлийн Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх салбар зөвлөлийн даргыг томилох тухай" мөн Зөвлөлийн 2015 оны 178 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Б.ЦОГОО



ТАЗ тогтоол 2016